

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 02

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/							
Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв 2.300,0 сая/төг	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	0	50	Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгууллагын даргын 2024.03.14-ний өдрийн А/39 тоот тушаалаар байгуулагдсан. 2024 оны төсөлд 5,8 тэрбум төгрөгөөр тусгаж, 2,4 тэрбум төгрөгийг батлуулсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд барилгын суурьт тулсан айлыг нүүлгэн газрыг шилжүүлэн Нийслэлийн Засаг даргын 2024.05.03-ны өдрийн А/498 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн 0000284276 дугаартай гэрчилгээг авсан. Мөн ВВSMO ХХК-тай 2024.09.06-ны өдөр 2024/64 тоот гэрээг байгуулан хамтран ажиллан, Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн дүгнэлт 2024.11.18-ны өдөр баталгаажиж, нийт төсөвт өртөг 6,4 тэрбум төгрөгөөр баталсан. Барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтийг хуулийн хугацаагаар 2024.12.13-ны өдөр нээж	50

						дүгнэлт, мэдэгдлийг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
1.2	Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын засварын ажлыг хийж, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах	Улсын төсөв 911.0 сая/төг	Барилгын засварын гүйцэтгэлийн хувь	0	100	Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/03 тоот тушаалаар байгуулагдан “Өгөөмөр уул” ХХК-тай ХЗДХЯ/20240101023, 24 тоот гэрээ байгуулсан бөгөөд 2024.08.25-ны өдрийн байдлаар гэрээний гүйцэтгэл 100 хувь хангагдсан.	100
1.3	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлж, бусдаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо	948.0	1.200.0	Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу 2022.05.01-ний өдрөөс 2024.11.24-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын 16 нас хүрсэн тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 1,439,716 иргэнд тоон гарын үсэг олгосон. үүнээс гар утсаар 566,659 иргэний үнэмлэхэд 873,057 /киоскоор 106,836/	100
			Тоон гарын үсэг олгох бусад байгууллагын цахим /киоск/ машины тоо	1270	1300	Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй олгох тоон гарын үсгийг улсын бүртгэлийн 104 киоск машин, бусад байгууллагын 1361 ширхэг цахим /киоск/ машинаар тус тус олгодог болсон. Үүнд: Гэрэгэ системс ХХК /киоск/-489 Голомт банк АТМ-аар -330 ХААН банкны АТМ-аар-442 ТҮЦ-100	
1.4	Иргэний цахим үнэмлэхийн бичилтийн үйлдвэрийн өргөтгөх	Улсын төсөв 3.7 сая/төг	Тооцоо судалгаа хийж, техникийн даалгавар боловсруулсан тоо	0	1	Иргэний үнэмлэхийн бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, системийн тооцоо судалгааг хийж, техникийн даалгаврыг 2024 оны 1 дүгээр сард боловсруулсан.	100

			Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, суурилуулсан тоо	1	2	Бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, систем худалдан авах тендерийн урилгыг 2024.01.18-ны өдөр www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тус тус байршуулж, “Смарт карт” ХХК-ийн тендер шаардлагад нийцсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.1.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох албан мэдэгдэл хүргүүлсэн боловч хуулийн хугацаанд Сангийн яамнаас ирүүлсэн “Гомдол хянасан тухай” 2024.03.12-ны өдрийн 03/1433 тоот албан бичигт дурдсаны дагуу “Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийж, мөн хуулийн 59 дугаар зүйлийн 59.10.2 дахь заалтын дагуу мэдэгдэж байна./ гэж заасныг үндэслэн тухайн багцын тендерийг дахин үнэлсэн. Ийнхүү үнэлгээгээр сайн тендерээр шалгарсан “Смарт карт” ХХК-тай 2024/34 тоот гэрээ байгуулав. Гэрээнд тусгагдсан тоног төхөөрөмж, программ хангамжийг УБЕГ-ын даргын 2024 оны А/57 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024.04.19-ний өдрийн 01 дугаартай актаар хүлээн авсан. Үүнд: • МХ2100 үндсэн систем • Системийн программ хангамж, • Системийн лиценз • Стандарт оролтын модуль • Санах ойд мэдээлэл бичих модуль • Лазер модуль	
--	--	--	---	---	---	--	--

						• Чанар шалгах модуль • Гаралтын модуль • MXi212 дугтуйлагч модуль Иргэний үнэмлэхэд бичилт хийх тоног төхөөрөмж, модуль хоорондын холболтын ажлыг 2024.04.22-ноос эхлүүлж, 2024.04.26-ны өдөр туршилтын ажлыг хийж, 21 аймаг 35,442, нийслэлийн 9 дүүрэг, үйлчилгээний нэгдсэн төв, нэг цэгийн үйлчилгээ 188,053, e-mongolia 32,914, элчин сайдын яамаар дамжин ирсэн 5,951 нийт 227,270 иргэний цахим үнэмлэх хэвлэн, хүргүүлсэн.	
1.5	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх	-	Үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн тоо	26	29	Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний 104 ширхэг киоск машиныг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, программ хангамжийг суулгаж, бүх тохиргоог хийж, шаардлагатай нэгжүүдэд хуваарилж, ашиглалтад оруулан анхан шатны нэгжүүдэд байршуулан, 29 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. Үүнд: Лавлагаа-20 /Иргэний улсын бүртгэл-12, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-2/ Үйлчилгээ-9 /Иргэний улсын бүртгэл-4, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-2, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-3/	100
			Нэмэгдүүлсэн зөөврийн төхөөрөмжийн тоо	3	4	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 24/7 төв, Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс,	

						Улаанбаатар төмөр замын вокзал, Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст, Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Гашуун сухайт” боомтод тус тус гадаад паспорт захиалгын өөртөө үйлчлэх бүрэн автомат 7 КИОСК машиныг суурилуулан иргэдэд үйлчилгээг үзүүлж байна.	
1.6	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	10	12	Улсын бүртгэлийн үйлчилгээнд дараах өгөгдлийн шинжилгээг хийсэн байна. Үүнд: 1. Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх загварчлал боловсруулан “Их өгөгдөл” ашиглан Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний ачааллын судалгаанд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар дүн шинжилгээ; 2. Иргэний улсын бүртгэл хөтөлж байгаа улсын бүртгэгч бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулж эхэлсэнтэй холбоотой алдаа, зөрчил гарч буй эсэхэд дүн шинжилгээ; 3. Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудаст дүн шинжилгээ; 4.Хүний нөөц сургалтын программ дээрх орон нутгийн албан хаагч тус бүрийн бие даах хичээл судалсан байдалд дүн шинжилгээ; 5.Иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэлд; 6.Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо хөдөлгөөн” эхэлсэнтэй холбогдуулан хоршооны улсын бүртгэлд;	100

						7.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлд; 8.Хамтын ажиллагаа сургалтын хэлтэс Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчид Удирдлагын академийн чиглүүлэх, дунд хугацааны болон, дундын давтан сургалт мөн ахлах, эрхэлсэн түшмэлийн сургалтад суралцсан байдалд; 9. Нийслэлийн үйлчилгээний төв, цэгүүдийн иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний мэдээ, Улсын бүртгэлийн цахим машин (КИОСК)-ны тоон мэдээ, судалгааны талаар; 10. Аймаг, нийслэлд гадаад паспорт, иргэний үнэмлэх, лавлагаа зэрэг иргэдийн түгээмэл авдаг үйлчилгээний өгөгдлийн дүн шинжилгээ (нэгжээр болон сар, өдрөөр); 11. Хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд бүртгэгдсэн шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны мэдээлэлд бүртгэгдэж, цахимжсан 455 хэрэг маргаан /2020-2024 оны хугацаанд хамрах бөгөөд ОӨУБЕГ-т холбогдох 2016 оны 6 хэрэг маргаан/-д.	
1.7	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, сурталчлах	-	Боловсруулж, батлуулсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тоо	5	8	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулсан. Үүнд: 1.УБЕГ-ын дарга, ТЕГ-ын даргын хамтарсан “Журам, маягт, загвар батлах тухай” 2024 оны А/11, А/22 дугаартай тушаалын хавсралтаар “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих	100

					журам, маягт, загвар"-ыг баталсан. (Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6699 дугаарт бүртгэгдсэн.) 2.УБЕГ-ын даргын "Журам батлах тухай" 2024 оны А/25 дугаартай тушаалын хавсралтаар "Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам"-ыг батлуулан, "Журамд өөрчлөлт оруулах тухай" 2024 оны А/64 дугаартай тушаалаар өөрчлөлт оруулсан. (Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6701 дугаарт бүртгэгдсэн бөгөөд захиргааны хэм хэмжээний актын өөрчлөлтөд нөлөөллийн шинжилгээг хийж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийлгэсэн.) 3.УБЕГ-ын дарга, ТЕГ-ын даргын хамтарсан "Журам батлах тухай" 2024 оны А/12, А/23 дугаартай тушаалын хавсралтаар "Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам"-ыг баталсан. (Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6700 дугаарт бүртгэгдсэн.) 4."Улсын бүртгэлийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам"-ыг 2024.04.25-ны өдрийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, УБЕГ-ын даргын 2024 оны А/63 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. УБЕГ-ын даргын дангаар болон бусад төрийн байгууллагатай хамтран баталсан нийт 14 захиргааны акт	
--	--	--	--	--	---	--

						захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байна.	
			Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилгааны тоо	5	8	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, тайланг зэрэг 15 удаагийн мэдээ, мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын веб сайт болон цахим хуудаст байршуулан нийтэлсэн байна. Үүнд: 1. “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам” 2. “Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам” 3. “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам” 4. УБЕГ-ын даргын 2014 оны “Загвар, журам шинэчлэн батлах тухай” А/1125 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан барьцаалбарын маягтын загвар, мэдэгдэл хүргүүлэх журам”-ын шинэчилсэн төсөл 5. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” 6. “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” 7. “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” 8. “Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” 9. “Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журамд өөрчлөлт оруулах	

						тухай” 10. “Барьцаалбарын маягтуудыг үйлдэх заавар, зөвлөмж” 11. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар 12. Шинэ маягтын танилцуулга /Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар/ 13.Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан 14.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 2 дугаар улирлын дотоод аудитын тайлан 15.Улсын бүртгэлийн ерөнхий газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан /2024 оны эхний хагас жил/.	
1.8	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх	14.3 сая/төг	Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгаа, контентын тоо	103	150	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас болон вэб сайтад 2024 онд нийт 215 удаагийн мэдээ мэдээлэл, постер, контент байгууллагын вэб сайтад байршуулан ажилласан. Үүнээс видео мэдээ /контент/ 32, постер мэдээ 65, бичмэл болон зурган мэдээ 118 удаа тавигдсан байна.	100
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.							
2.1	“Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон цэг”-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагуудын	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн	0	500	Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор иргэн, хуулийн этгээдийн байгаа байршилд нь хүрч зөөврийн буюу хөдөлгөөнт үйлчилгээгээр иргэний улсын бүртгэлийн 10, хуулийн этгээдийн	100

		тусламж дэмжлэг	үйлчилгээний тоо			улсын бүртгэлийн 8, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9 төрлийн лавлагаа, үйлчилгээ үзүүлж байна. Тайлант хугацаанд манай байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, зорилтод бүлгийн иргэний хүсэлтийн дагуу оршин суугаа хаяг, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, уул уурхайн кемп, эмнэлэг, ерөнхий боловсролын сургуулиудад зөөврийн буюу хөдөлгөөнт үйлчилгээг зохион байгуулж 18,833 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.	
			Нэмэгдсэн 24/7 цэгийн тоо	0	2	Улсын бүртгэлийн чанар, шуурхай байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1 дүгээр давхарт, Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Багануур дүүрэг, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дэргэд, Дүнжингарав ННҮТ, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Орхон, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Дундговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Төв, аймгийн Засаг даргын тамгын газарт байрлах Цахим төвд, улсын бүртгэлийн “Цахим үйлчилгээний 24/7 төв”-г тус тус нээж ашиглалтад оруулаад байна.	
2.2	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн	-	Нэмэгдсэн лавлагаа, үйлчилгээний тоо	107	115	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia, e-business/-д нийт 123 лавлагаа, үйлчилгээг шилжүүлээд байна. Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 13, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 7, нийт 20	100

	үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх					(давхардсан тоогоор) үйлчилгээг шинээр нэвтрүүлэв. Үүнд: 1. Өв залгамжлах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх 2. Өмчлөгчийн үүсгэн байгуулсан хуулийн этгээдээс иргэнд, иргэнээс үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн өмчлөлд өмчлөх эрх шилжсэнийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх 3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах /хаяг өөрчлөгдөх/ 4. Эд хөрөнгийн барьцаалбартай барьцааны гэрээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх 5. Эд хөрөнгийн барьцаалбаргүй барьцааны гэрээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх 6. Эд хөрөнгийн барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл хийх 7. Эд хөрөнгийн барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл хийх 8. Барьцааны эрх дуусгавар болсныг эрхийн бүртгэлд бүртгэх 9. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааг эрхийн улсын бүртгэлд бүртгэх 10. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэх 11. Барьцааны гэрээнээс бусад гэрээ дуусгавар болсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэх	
--	-------------------------------------	--	--	--	--	---	--

						12. Барьцааны гэрээнээс бусад гэрээнд өөрчлөлт орсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэх 13. Архивын баримтаас хуулбар олгох 14. Тамга тэмдгийн хяналтын дугаар авах 15. Шинээр үүсгэн байгуулагдсан "Хоршоо"-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх 16. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн лавлагаа 17. Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гишүүний лавлагаа 18. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн лавлагаа 19. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн талаарх лавлагаа 20. Хуулийн этгээдтэй лавлагаа	
			Цахимаар үзүүлсэн улсын бүртгэлийн тоо	5.266.098	5.300.0	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/-д 123 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-аар үзүүлж байгаа бөгөөд нийт 18,075,802 лавлагаа, үйлчилгээг олгосон байна.	
2.3	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох ажлыг үе	-	Цахим хэлбэрээр олгосон газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх эрхийн улсын	0	25	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох эрх зүйн зохицуулалтыг тусгаж ХЗДХЯ-нд	30

	шаттайгаар эхлүүлэх /blockchain/		бүртгэлийн гэрчилгээний тоо			хүргүүлсэн бөгөөд 2024.05.08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. Мөн “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системийн программ хангамжийн бодлогын даалгавар”-ыг боловсруулан МТГ-т хүргүүлсэн.	
2.4	Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системийг боловсронгуй болгох	-	“Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулсан нотариатчидын тоо	89	189	УБЕГ-аас Монголын Нотариатчидын танхимын гишүүн нотариатчидтай байгуулсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл солилцох тухай” нийт 273 гэрээ гэрээний нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна.	100
			Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо	0	100	УБЕГ-аас систем хөгжүүлэлтийн ажил бүрэн хийгдэж дууссан бөгөөд 2024.10.28-ны өдрөөс нэвтрүүлэх тухай албан бичгийг 2024.10.25-ны өдрийн 5/13357 дугаартай албан бичгээр Монголын Нотариатчдын танхимд хүргүүлж системийг хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн. 2024.11.20-ны өдрийн байдлаар нийт 3 гэрээг зуучлалын системээр бүртгэсэн байна.	
2.5	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийн хэрэглээ, цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх	-	Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк, санхүүгийн байгууллагын тоо	2	4	Барьцааны гэрээ болон барьцааны гэрээний дуусгавар болгох мэдүүлгийг цахимаар хүлээн авах, онлайн мэдүүлгийн хөгжүүлэлтийг Голомт банк, Монголын Нотариатчдын танхим болон МИК ОССК ХХК гэсэн 3 байгууллага хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Капитрон банк уг системийн хөгжүүлэлтийг 2024.04.23-ны өдрөөс эхлүүлж 2024.06.13-ны өдрөөс туршилтын мэдүүлгийг илгээх ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Хас банкны систем хөгжүүлэлт мөн эхэлсэн.	100

			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо	16	66	Голомт банкны системийн шинэчлэлтийн ажил удаашралтай хийгдэж 2024.10.15-ны өдрөөс систем хэвийн ажиллаж эхэлсэн бөгөөд 55 барьцааны гэрээг цахимаар ирүүлснийг бүртгэж боловсруулсан.	
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	3	23	Барьцааны гэрээний дуусгавар болгох үйлчилгээний мэдүүлгийг цахимаар хүлээн авч боловсруулах системийг 2024.03.01-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлснээс хойш 2024.11.20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 5,052 мэдүүлэг хүлээн авч боловсруулсан байна.	
2.6	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх	-	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн сан үүсгэж, өөрчлөлт оруулсан хувь	20	60	МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга ажиллаж байна. Тус ажлын хэсгийн анхдугаар хурал 2024.11.22-ны өдөр зохион байгуулагдаж, УБЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд нар оролцож "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Улсын бүртгэлийн ерөнхий газартай холболт хийж дундын мэдээллийн санг байгуулах ажлын талаарх танилцуулга"-ыг хийсэн.	70
			Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн хувь	0	50		

						УБЕГ, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан 2022.05.31-ний өдрийн А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь 2024.11.20-ны өдрийн байдлаар 4 удаа уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтуудаар газрын кадастрын мэдээллийн системд өмчлөлийн газрын бүртгэл мэдээллийг түүхчилсэн байдлаар хөрвүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв бүртгэхэд бүртгэлийн байгууллагаас гарах өгөгдөл мэдээллийг авах замыг тодорхойлж, мэдээлэл солилцохоор Үндэсний дата төвд байрлах баазад газрын үйлчилгээний түүхчилсэн мэдээллийн сервисийг үүсгэж, ГЗБГЗЗЕГ-аас авах хаягийн мэдээллийн багануудыг тодорхойлж хүргүүлсэн. Хаягийн санг нэгтэх зорилгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь кадастрын дугааргүй бүртгэлийг нөхөж оруулах ажлын явц 2024.11.25-ны өдрийн байдлаар нийт 128,783 нэгж талбарын дугаар буюу нийт нөхөж оруулах шаардлагатай бүртгэлийн 62.7%-ийг нөхөж оруулаад байна. Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 2024.11.25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 7,666 хаяг өөрчлөгдсөн бүртгэл хийгдсэн байна.	
2.7	Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологи /NFC/-ийг нэвтрүүлэх	3.398.5 сая/төг	Иргэний үнэмлэхэд NFC технологийг ашиглан мэдээлэл унших	0	1	Монгол Улсын иргэний цахим үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох /NFC/ технологийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Монгол Улсын	100

			программ хангамжийг хөгжүүлсэн тоо			иргэний үнэмлэхийн тодорхойлолт загварыг шинэчлэн батлах тухай” 374 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт 2024.01.31-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, мөн өдрийн 52 дугаар тогтоолоор батлуулсан. Иргэний үнэмлэхэд NFC технологийг ашиглан мэдээлэл унших программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлыг хийж дууссан бөгөөд 2024 оны 1 дүгээр сараас хэвлэлт хийж эхэлсэн шинэ бэлдцийн апплет хувилбарыг 5.0.2 болгосон. Ингэснээр NFC технологийг ашиглах бүрэн боломжтой болсон тул банкнууд болон хамтрагч байгууллагуудад иргэний үнэмлэх уншдаг “dll” гарган өгч, байгууллагын цахим хуудаст гарын авлага байршуулсан.	
			Шинэ чиптэй иргэний үнэмлэхэд бичилт хийсэн тоо	0	250.000	Иргэний үнэмлэх бичилтийн үйлдвэрийн Datacard MX2100, MX-6000 загварын MX3, MX2 хэвлэх төхөөрөмжид техникийн үзлэг үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийж, 21 аймаг 35,442, нийслэлийн 9 дүүрэг, үйлчилгээний нэгдсэн төв, нэг цэгийн үйлчилгээ 188,053, e-mongolia 32,914, ДТГ-аар дамжин ирсэн 5,951 нийт 262,360 иргэний цахим үнэмлэх хэвлэн, хүргүүлсэн.	
2.8	Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулах	Улсын төсөв	Цахимжуулсан хувийн хэргийн тоо	162.122	245.000	Иргэний улсын бүртгэлийн нөхөн бүрдүүлэлт болон нэмэлтээр хүлээн авсан 146,246 хувийн хэргийн 444,908 хуудас баримтыг системд цахимжуулсан.	90
			Иргэний баримтын архивын	0	82.000	Иргэний баримтын архивын тодорхойгүй төлөвт байгаа эх нотлох баримтын судалгааг аймаг, Нийслэлийн	

			тодорхойгүй төлөвт байгаа эх нотлох баримтыг цахимжуулсан хувийн хэргийн тоо			Улсын бүртгэлийн хэлтсүүдээс авсан бөгөөд нийт 53,306 хувийн хэрэг цахимжуулаагүй тодорхойгүй төлөвт байгаа хувийн хэргийн тоог нэгтгэн гаргаж, тус баримтуудыг эх нотлох баримттай тулган шалгаж, 53,300 хувийн хэргийн 79,950 хуудас баримтыг цахимжуулсан.	
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ыг нууцлал бүхий сүлжээ /VPN/-д холбож, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн онлайн системд холбох	-	Сүлжээнд холбосон ДТГын тоо.	9	19	УБЕГ-ын баталсан удирдамжийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэгт заасны дагуу гадаад улсад амьдарч байгаа иргэдийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгуульд оролцох эрхийг хангах, санал өгөх боломжийг бүрдүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор иргэний улсын бүртгэлийн оффлайн системийг нууцлал бүхий сүлжээ /VPN/-д холбох, иргэний улсын бүртгэлийн ажилтны улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд дэмжин туслах, чадавхжуулах, иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай танилцах, хянах, бүртгэл хариуцсан ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээлэл солилцох болон гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-т VPN сүлжээ тавих шийдлийг гаргаж, холбогдох лиценз, программ хангамжийг бэлэн болгосон. 2024.05.11-ний өдрөөс 2024.05.29-ний өдрийг хүртэл хугацаанд Тагнуулын	100

						байгууллагын зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, хилийн чанадад ажиллаж байгаа нийт 32 ДТГ-ын бүртгэлийн ажилтны тоног төхөөрөмжийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд холбож /VPN/ сонгогчийн бүртгэлийн тоног төхөөрөмж, программ хангамжийг хүлээлгэн өгч ажилласан. Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд холбосон ДТГ нийт 45 байна. Сонгуулийн санал авах өдрийн бэлтгэл ажлын хүрээнд сонгуулийн ирц бүртгэлийн программ хангамжийг суулган үйлдлийн систем, оффисын программын activation кодыг шинэчилж, программ ашиглалтын хэвийн үйл ажиллагааг шалган тестийн баазыг татан суулгасан.	
3.2	Хуулийн этгээдийг мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээ шинэчлэх	-	Эрсдэлийн үнэлгээ хийх	0	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын дарга Ж.Аюуш, гишүүнээр улсын ахлах бүртгэгч Б.Лхагвасүрэн нар томилогдон ажиллаж байна. “Хуулийн этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг шинэчлэх” ажлын төлөвлөгөө батлан, ажлын хэсгийн 4 удаагийн хурал, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын 3 удаагийн уулзалт хийж, төлөвлөгөөнд тусгасан ажлууд хариуцагч байгууллагууд тайлагнах хэлбэрээр нэгтгэгдэн, нийт 20 үзүүлэлт бүхий ажлын 13 дахь ажил буюу	70

						“Эрсдэлийн тайланг боловсруулах” түвшинд явагдаж байна.	
3.3	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлэх, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах	-	Илрүүлсэн зөрчлийн тоо	0	50	“Эцсийн өмчлөгчийн бүртгэлийг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2024.10.30-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан ажиллаж байна. Уг асуудлын хүрээнд эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй хуулийн этгээдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулахгүй байх арга хэмжээг Сангийн яам, Татварын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. УБЕГ-ын даргын 2024.10.29-ний өдөр хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэх үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлын удирдамжийг батлуулан хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар 48 зөрчил илрүүлэн арилгуулхаар ХЭУБГ-т албан шаардлага хүргүүлсэн. Эцсийн өмчлөгчөө бүртгүүлээгүй 53,705 хуулийн этгээдийн эрх бүхий этгээдэд төрийн үйлчилгээний E-Mongolia цахим системээр дамжуулан эцсийн өмчлөгчөө бүртгүүлэх тухай мэдэгдлийг 2024 оны 05, 10 дугаар саруудад тус тус хүргүүлсэн.	100
			Зөрчил арилгасан тоо	0	50		
3.4	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	Хяналт шалгалтын газрын 2024 онд хийх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, УБЕГ-ын даргаар батлуулсан. Уг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:	100

						1.Иргэний улсын бүртгэлийн газар /2024.01.08-31/, Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /2024.03.15-30/, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /2024.04.22-05.31/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар /2024.04.22-0 5.31 тус тус үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт, Говьсүмбэр, Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд /2024.04.22-05.30/, хяналтын улсын байцаагч нарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд /2024.10.30-11.12/ гүйцэтгэлийн шалгалт; 2.“Улсын ахлах бүртгэгч нарын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлын удирдамж”-ийн дагуу 2024.01.08-ны өдрөөс 02 дугаар сарын 29-ний өдрийн хооронд Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд, Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нарын үйл ажиллагаанд, 2024.09.09-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалтыг тус тус хийв. Шалгалтын дүнтэй холбогдуулан улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчиж бүртгэл хөтөлсөн 5 улсын ахлах	
--	--	--	--	--	--	--	--

						бүртгэгч нарт Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны Б/171, Б/186, Б/187, Б/198 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсаас хилийн чанадад суугаа зарим Элчин сайдын яамны консулын ажилтанд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хүрээнд Монгол Улсаас АНУ-д суугаа Элчин сайдын бүртгэсэн иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэх талаар консулын ажилтантай хамтран ажиллаж 11 зөрчил илэрсний 5 зөрчлийг шийдвэрлэж, Монгол Улсаас БНФУ дахь ЭСЯ-нд 2010-2016 онуудад алдаатай бүртгэгдсэн 14 иргэний ИУБ маягт, хүсэлт, баримт бичгийн жагсаалтыг нотлох баримтын хамт консулын ажилтанд хүлээлгэн өгч, бүртгэлийг зөвтгөх, үнэн зөв байх зарчимд нийцүүлэх талаар тус тус хууль зүйн зөвлөмж өгч ажиллав.	
3.5	Архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	0	100	Архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт ажлын төлөвлөгөөг 2024.02.15-ны өдөр 4 арга хэмжээний хүрээнд батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай. Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлынн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон	100

						холбогдох журамд заасны дагуу иргэний улсын бүртгэлийн нотлох баримтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүрэн гүйцэт, үнэн зөв цахимжуулж бүртгэсэн эсэхэд 2024.03.20-ны өдрөөс 05.01-ний өдрийн хугацаанд 2022 оноос 2024 онд бүртгэгдсэн бүртгэлийн 43,254 хуудас архивын эх нотлох баримтад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар цахимжуулах явцад төлөв сонгож, баталгаажилт хийгдээгүй 8,773, иргэний регистрийн дугаар өөрчлөгдсөний улмаас өөрчлөгдсөн регистрийн дугаарт цахимжиж бүртгэгдээгүй 315 баримтыг тус тус цахим санд баталгаажуулав. - “Нийслэлийн Баянгол, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хийх шалгалтын удирдамж”-ийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд иргэний улсын 70,748 бүртгэлийн нотлох баримтыг мэдээллийн санд цахимжуулсан эсэхэд шалгалт хийв. - “Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн	
--	--	--	--	--	--	--	--

						цахимжуулалтын үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу шалгалтын хүрээнд хуулийн этгээдийн улсын 6,157 бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын 22,855 бүртгэлийн цахимжуулалт, хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллав. - Лавлагаа олголтын байдалд хяналт шалгалт хийж, улсын хяналтын ахлах байцаагчийн 2024 оны 1628 дугаар дүгнэлт гарган 2023 оны 5 лавлагааг хүчингүй болгож, Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 6 улсын бүртгэгчид УБЕГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан.	
3.6	Бодлогын баримт бичиг болон захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо.	2	2	Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тайланг 2024.06.07-ны өдрийн 1/7858, 2024.12.02-ны өдрийн 1/15103 дугаар албан бичгээр тус тус ХЗДХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлэв.	100
			ХЗДХЯ-нд хүргүүлсэн тайлангийн тоо.	12	12	Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны	

						байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” -ын дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” (2024 оны 5 дугаар сарын байдлаар), Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд (сар бүр), Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд (сар бүр) явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг сар бүрийн 05-ны дотор ХЗДХЯ-ын ХШҮДАГ-т цахим шуудангаар хүргүүлэн ажиллав.	
			Хүргүүлсэн зөвлөмжийн тоо.	2	2	Үнэлгээний мөрөөр газруудад 2024.06.24-ны өдрийн 508-515 дугаар дотоод албан бичгээр зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллав. Жилийн эцсийн ХШҮ-ний мөрөөр зөвлөмж хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.	
3.7	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх	-	Шилэн дансны хуулийг хэрэгжилтийн хувь.	99.8	99.9	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн төсөвт болон төвлөрүүлэн захирагчийн байгууллагын мэдээллийг шилэн дансны цахим хуудас болон төвлөрүүлэн захирагчийн цахим хуудсанд сар бүрийн 07-ны өдрийн дотор байршуулсан. Шилэн дансны нэгдсэн санд байршуулсан мэдээлэл бүрийг улсын бүртгэлийн байгууллагын албан ёсны цахим хаяг болох burtgel.gov.mn -д тухай бүр байршуулж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн 2023 оны жилийн эцсийн	100

						нэгдсэн тайланг 2024.01.17-ны өдөр ХЗДХЯ-ны дотоод аудиторт undraa@mojha.gov.mn, 2024 оны 1 дүгээр улирлын тайланг 1/5083 дугаар албан бичгээр болон ХЗДХЯ-ны ахлах шинжээчид tumurochir@mojha.gov.mn цахим шуудангаар, эхний хагас жилийн тайланг 2024.07.05-ны өдрийн 2/9117 тоот албан бичгээр, 3 дугаар улирлын тайланг 2024.10.25-ны өдөр 7/13340 албан бичгээр тус тус ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Жилийн эцсийн нэгдсэн тайланг хуваарийн дагуу дараа оны 01 дүгээр сард хүргүүлэхээр бэлтгэж байна. Шилэн дансны хуулийг хэрэгжилт 99.8 хувь.
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.	3910	3910	Хууль тогтоомжийн дагуу 2024 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны 2023 оны жил эцсийн тайланг 2024.01.07-ны өдөр мөн худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авалтын тендерийн урилга, үр дүнг байгууллагын шилэн самбар www.tender.gov.mn, www.shilendans.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тус тус байршуулсан. Байгууллагын 23 нэгжээс сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч нэгтгэн, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, байгууллагын төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, өглөг, авлагын мэдээ, тооцоо нийлсэн актын

						хуулбарын хамт сар бүрийн 4-ний өдрийн дотор ХЗДХЯ болон байгууллагын сайт болон мэдээллийн самбарт байршуулж байна. Улсын төсөвт төвлөрсөн орлогын мэдээг Сангийн яамны холбогдох мэргэжилтэнтэй сар бүрийн 5-ны өдрийн дотор тулган тооцоо нийлж баталгаажуулан ажиллаж байна. УБЕГ, аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтэс, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ны 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг 24 нэгжээр нэгтгэн, холбогдох тодруулгын хамт гарган баталгаажуулсан. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2-т заасан нийтэд мэдээлэх 23 төрлийн 3,694 мэдээллийг байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны нэгдсэн санд байршуулсан мэдээлэл бүрийг улсын бүртгэлийн байгууллагын албан ёсны цахим хаяг болох burtgel.gov.mn-д тухай бүр байршуулж байна.	
3.8	Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь.	100	100	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох тодруулгын хамт 2024.03.04-ний өдөр Үндэсний аудитын газарт, мөн аудитаар баталгаажуулсан 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох тодруулгын хамт 2024.03.25-ны өдөр ХЗДХЯ-нд тус тус хүргүүлэн ажилласан. Улсын бүртгэлийн ерөнхий	100

						газрын 24 нэгжийн 2023 оны нэгдсэн санхүүгийн тайланд УБЕГ, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК нь "хязгаарлалтай" дүгнэлт авсан. Үндэсний аудитын газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар гарсан зөрчлийг арилгах, дахин гаргахгүй ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг гарган 2024.04.04-ны өдөр тус газарт хүргүүлсэн бөгөөд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орсон аудитын биелэлтийг 2024.05.31-ны өдрийн байдлаар гарган нийт 9 зөрчлийг 97,8 хувиар биелүүлж тайланг хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 1/2 тоот албан даалгаврын дагуу төлөвлөгөөний биелэлтийг нотлох баримтын хамт 2024.05.28-ны өдрийн 1/7213 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2024 оны 03-р улирлын хэрэгжилтийн мэдээг 2024.08.23-ны өдрийн 1/10384 дугаар албан бичгээр ХЗДХЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлсэн. Жилийн эцсийн тайлан мэдээг ХЗДХЯ-наас ирүүлсэн хугацааны дагуу 2024.12.10-ны дотор хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
3.9	Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх	-	Эрсдэлийг бууруулсан хувь.	29	5	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 тушаалаар шинэчлэн батлагдсан "Харъяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх менежментийн төлөвлөгөө"-г удирдлага болгон Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан, баталж хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын эрсдэлийн тайлан мэдээ	100
			Зөвлөмж хүргүүлсэн тоо	2	2		

						боловсруулан ажиллах 24 албан хаагчдыг эрсдэлийн менежментийн сургалтад 06 дугаар сард хамруулж, шалгалтад тэнцсэн албан хаагчид сертификат хүлээн авч, нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн, эрсдэл хариуцсан албан хаагчдад 2024.10.24-ний өдөр практик цахим сургалтыг зохион байгуулж 155 албан хаагчид хамрагдсан. 2024 оны Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлтийг газар, хэлтсээс 2024.11.25-ны өдөр хүлээн авч, нэгтгэсэн тайланг 2024.11.30-ны өдрийн 1/15075 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлэв. Эрсдэлийн үнэлгээгээр 9 хувиар буурсан байна.	
3.10	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах	-	Эрсдэл бууруулсан тоо	55	45	“Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, 5 ангилал, 21 арга хэмжээг төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны 2024 оны эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшинг зорилтот эрсдэлийн түвшин болон хүлээн зөвшөөрөх хязгаартай харьцуулан эрсдэлийг ач холбогдлоор нь дүгнэхэд маш өндөр эрсдэл 7 байсан нь буурч өндөр эрсдэл рүү шилжсэн, өндөр эрсдэлтэй байсан эрсдэлээс 3 эрсдэл нь эрсдэлтэй боловч давтамж их рүү буурсан тул нийт эрсдэлийн үнэлгээ 19.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100
3.11	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах	-	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн тоо	1	1	УБЕГ-ын даргын 2024 оны А/140 дугаар тушаалаар Хэрэглэгчийн үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан 2024 оны үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн	100

						үнэлгээ” хийх ажлыг гүйцэтгүүлэхээр “Гранд Дата” ХХК-г сонгон шалгаруулж, гэрээ байгуулан 2024.09.11-ний өдрөөс 2024.11.11-ний өдрүүдэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгүүлсэн. Гэрээний дагуу 2024.11.11-ны өдөр “Хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-г хүлээн авч, байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	
3.12	Сервер, хадгалах төхөөрөмж, тог баригч, сүлжээний тоног төхөөрөмжийн эд анги, хөргөлтийн систем, генератор, тогтворжуулагчийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх	Улсын төсөв 98.0 сая/төг	Тоног төхөөрөмжүүдэд гэмтэл гарсан үед яаралтай засварлахад шаардлагатай сэлбэг хэрэгсэл нэмэгдүүлсэн тоо	0	10	УБЕГ-ын даргын 2024 оны А/06 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо “Мэдээллийн технологийн үйлчилгээ” нээлттэй тендер шалгаруулж Саммит компьютер ХХК шалгаран 2024 оны 2024/11 дугаартай “Худалдах худалдан авах гэрээ”-г байгуулан дараах тоног төхөөрөмж, лицензийн худалдан авалтыг хийсэн. -Dell All Flash Unity 380 серверийн хард диск 1 ширхэг, -Dell All Flash Unity 880 серверийн хард диск 1 ширхэг -Dell NX3230серверийн хард диск 6 ширхэг -Dell R740 серверийн хард диск 4 ширхгийг тус тус худалдан авч нөөц бүрдүүлсэн.	100
			УБЕГ-ын серверийн өрөөнд суурилагдсан хөргөлтийн систем, цахилгаан тасарсан үед нөөц эх үүсвэрээр	2	4	Серверийн өрөөний орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор агааржуулалтын систем /Air condition/, дизель генераторт үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Цахилгаан тасарсан үед нөөц эх үүсвэрээр хангах зорилгоор “Саммит компьютер технологи” ХХК-аар генераторт сервис үйлчилгээг хийж гүйцэтгүүлсэн ба 1 жилийн хугацаатай	

			хангах генераторт сервис үйлчилгээ хийсэн тоо			сервис үйлчилгээ хийх 2024/11 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Тог баригчийн өрөөний агааржуулалт, хөргөлтийн системийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор Midea MAV008T1N2S Precision төрлийн air condition худалдан авч суурилуулсан.	
3.13	Мэдээллийн санг ашиглаж буй албан хаагчдын компьютерт хортой кодын эсрэг хамгаалах программ суулгах	Улсын төсөв 25 сая/төг	Худалдаж авсан лицензийн тоо	0	1	Мэдээллийн санг ашиглаж буй албан хаагчдын компьютерын хэвийн ажиллагааг хангах зорилгоор Kaspersky Endpoint Security for Business-Advanced 1year Renawal License 150 ширхгийг 2024/11 дугаартай гэрээгээр худалдан авалт хийж албан хаагчид болон серверүүдэд суулгасан.	100
3.14	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллах	Улсын төсөв 77.6 сая/төг	Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах программ хангамжийг сунгасан лицензийн тоо	9	9	ТЕГ-аас мэдээллийн систем, сүлжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 2 жил тутамд тус байгууллагад хийдэг бөгөөд 2024 оны 05 дугаар сард мэдээллийн аюулгүй байдлын аудит хийсэн. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийсэн үр дүнд “Маш өндөр” түвшний эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн төлөвлөгөө”-г боловсруулан, баталж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор FortiGate EMS эрхийг 1 жилийн хугацаагаар, FortiGate 601E эрхийг 2 жилийн хугацаагаар сунгаж тохиргоог хийсэн. 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд Domain controller system-ийг 100 хэрэглэгчийн эрхтэй нэвтрүүлсэн бөгөөд УБЕГ-т	100

					дотоод сүлжээ ашиглан мэдээллийн санд хандан ажилладаг 73 албан хаагчийн компьютерт суулгаж аюулгүй байдлыг ханган ажилласан. Мөн Domain controller system-ийг ашиглан Microsoft Windows SMB серверт хандах эрх, NFS /Network File System/ хандах эрхийн тохиргоог хийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 3.Мэдээллийн санг ашиглаж буй албан хаагчдын компьютерын хэвийн ажиллагааг хангах зорилгоор Kaspersky Endpoint Security for Business-Advanced 1year Renawal License 150 ширхгийг 2024/11 дугаартай гэрээгээр худалдан авалт хийж 120 албан хаагчид компьютерт болон серверүүдэд суулгасан. 4.Тодорхой IP хаяг дээр ажиллаж байсан Oracle Database серверийг унтраасан боловч шаардлагатай тохиолдолд ажиллуулсан хэвээр байна. 5.Microsoft SQL серверүүд, тодорхой IP хаягтай серверийг тус тус унтраасан. 6.Сервер рүү код ажиллуулж халдлага үйлдэх эрсдэлийг зогсоох зорилгоор "Telnet"-ийг хаасан. 7.Хуучин веб серверт ашиглагдаж байсан үйлдлийн системийг шинэчилсэн. 8."Gitlab"-ийг сүүлд гарсан хувилбараар шинэчилсэн. 9.Серверт хандахад баталгаажуулалтыг Bypass хийх эрсдэлийг буруулах зорилгоор Opnfire-ийг ашиглахаа больсон.	
--	--	--	--	--	---	--

						10.Microsoft Windows XP, 2003, 2008, P2 үйлдлийн системтэй серверүүдийн системийг 2019 болгон шинэчилсэн. 11.RDP сервер дээр NLA /Network Level Authentication/-ийг идэвхжүүлэн тохиргоог хийж гүйцэтгэсэн. 12.App debug-ийг false болгож идэвхтэй ажиллаж байгаа Debug-ийг хаасан. 13.Кибер аюулгүй байдлын тухай хууль, нийтлэг журам, стандартыг хэрэгжүүлэх болон салбарын кибер аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлуудыг боловсруулан 2024.09.24-ний өдөр ХЗДХЯ-д хүргүүлэн ажиллав.	
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
4.1	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	3.039.0 сая/төг	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2023.11.06-ны өдрийн А/1712 тоот тушаалаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Сонгуулийн ерөнхий хорооны 2024.01.09-ний өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан "Монгол Улсын	100

						Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь"-т нийцүүлэн боловсруулж, 6 дэд ажлын хүрээнд нийт 112 ажил хийхээр төлөвлөсөн. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангасан тухай тайланг 2024.07.08-ны өдрийн 1/9174 тоот албан бичгээр ХЗДХСайдад хүргүүлсэн.	
4.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах	2.546.7 сая/төг	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг 5 бүлэг бүхий 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Сонгууль зохион байгуулсан тухай тайланг 2024.10.10-ны өдрийн 1/12668 тоот албн бичгээр ХЗДХСайдад хүргүүлсэн.	100
Зорилт 5. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
5.1	Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	Төсөл, хөтөлбөр	ADB болон КОЙКА олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо.	0	2	Улсын бүртгэлийн байгууллагын системийн үйл ажиллагааг дэмжих, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хүрээнд: 1.Азийн хөгжлийн банкны Техникийн туслалцааны Тусгай сангаас буцалтгүй тусламж хэлбэрээр санхүүжүүлж байгаа “Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх,	100

						төвлөрлийг сааруулах” төслийг 2024 оны 1 дүгээр улирлаас хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийн Санамж бичигт 2024 онд хэрэгжүүлэхээр тусгасан төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн. Үүнд: Нээлтийн семинар, хэлэлцүүлгийг 2024.04.04-ний өдөр зохион байгуулж, тус төслийн удирдах хороог 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд гишүүдэд Сангийн яам, ХЗДХЯ, ЦХХХЯ, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны төлөөлөлүүд орж, төслийн захирлыг томилсон тушаал 2024.03.14-ний өдөр тус тус батлагдсан. Төслийн баримт бичиг, харилцан ойлголцолын санамж бичигт дурдсанчлан бодлогын даалгавар, Азийн хөгжлийн банкнаас урьдчилгаа төлбөр гаргуулан авах тухай, мөн шууд төлбөр хүссэн тухай албан бичгүүдийг тус тус боловсруулан Сангийн яам, Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгчийн газарт хүргүүлсэн. Төслийн хүрээнд бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлэхэд шаардлагатай ажлын даалгаврын төсөл боловсруулах, ажил гүйцэтгэгчийн гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, тайлан баталгаажуулах, эх код хүлээн авах, хамтран хэрэгжүүлэгч талуудын уялдаа холбоог хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд нийт 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж нийт 256 албан хаагч хамрагдсан байна. Төслийг	
--	--	--	--	--	--	--	--

					эрчимжүүлэх ажлын хүрээнд 6 удаагийн уулзалт зохион байгуулсан. 2.Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Ухаалаг Засаг 2” төслийн хэрэгжилтийн талаар Дэлхийн банк болон УБЕГ-ын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, МУЗГ-аас төслийг соёрхон баталж албан ёсоор 2023.04.06-ны өдрөөс эхлүүлэн, 2024 онд төслийн хүрээнд “Ажлын даалгавар”-ыг боловсруулж, төслийн нэгжид болон ЦХХХЯаманд тус тус хүргүүлсэн. Төслийн зорилго нь Улсын бүртгэлийн нэгдсэн системийн хуулбар буюу одоо ажиллаж буй системтэй яг ижил горимоор ажиллах системийг газар зүйн өөр бүс нутагт байршуулах юм. <i>(Бүртгэлийн системийн нөөц төвийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын гамшгийн үеийн нөхөн сэргээх төв буюу Дархан-Уул аймагт байрлах дата төвд байршуулна)</i> 3.БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын санхүүжилтээр тус улсын шүүхийн харьяа Төрийн албан хаагчдын сургалтын төвөөс 2023-2025 онд хэрэгжүүлэх “Улсын бүртгэлийн системийн чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 09 дүгээр сард 15 албан хаагчийг сургалтад хамруулсан.	
		Гадаадад туршлага судалсан, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	45	55	БНСУ-ын Шүүхийн харьяа Төрийн албан хаагчдын сургалтын төвтэй хамтран аймаг, нийслэлийн газар хэлтсийн 14 албан хаагч, КОЙКА-ын санхүүжилтээр тус улсын шүүхийн харьяа Төрийн албан хаагчдын сургалтын төвөөс 2023-2025 онд хэрэгжүүлэх “Улсын бүртгэлийн системийн чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 15 албан	

						хаагч, БНХАУ-ын Элчин сайдын яам болон Хятад улсын худалдааны яамтай хамтран зохион байгуулдаг “Нэг бүс Нэг зам дагуух улс орнуудын төрийн албан хаагчдад зориулсан Амьжиргааны аюулгүй байдал ба нийтийн засаглал”-ын сэдэвт семинарт 3 албан хаагч, Шанхай хотын бизнесийн сургуулиас зохион байгуулсан “Хөгжиж буй орнуудын жижиг дунд үйлдвэрлэлийн чадавхыг бэхжүүлэх нь” семинарт 3 албан хаагч, Индонез улсын Жакарта хотноо зохион байгуулагдсан Мөнгө угаах, терроризмтой тэмцэх үйл ажиллагааны олон улсын ээлжит форумд 1 албан хаагч, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс болох Хонконгт байрлах үйлдвэрлэгчийн бүсийн сургалтын төвд 5 албан хаагч нийт 41 албан хаагчийг сургалтад хамруулсан байна.	
5.2	Гадаадын төсөл, хөтөлбөр, ижил түвшний бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг тухай бүр боловсруулж, хэрэгжүүлэх.	-	Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан байгууллага, төсөл, хөтөлбөрийн тоо	2	4	ОХУ-ын Улсын Бүртгэл, Кадастр, Зураг зүйн газар /Росреестр/-тай 2017 онд хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулагдсан. Хоёр байгууллагын харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг 2024.01.30-ны өдөр ирүүлсэн цахим шууданг үндэслэн тус байгууллагатай хамтран ажиллахад чиглэл хүсэх тухай УБЕГ-ын даргын 2024.03.11-ний өдрийн 1/3141 тоот албан бичгийг ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газарт хүргүүлсэн. ОХУ-ын Росреестр байгууллага болон бүртгэлийн байгууллагын холбогдох мэдээ, мэдээллийг албан бусаар хүргүүлэн ажиллаж хамтын ажиллагааны талаарх	50

						чиглэл өгөх ХЗДХЯ-ны хариу албан бичгийг 2024.04.10-ны өдрийн 3/1724 тоотойр хүлээн авч холбогдох байгууллагуудад албан бичгээр мэдэгдсэн.	
5.3	Бүртгэлийн системд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг шинэчлэн, нөөцийг бүрдүүлэх	ADB төсөл	Төсөлд тусгагдсан тоног төхөөрөмжийг шинэчилсэн тоо	0	1	Бүртгэлийн системд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн судалгааг шинэчлэх саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкны албан ёсны сайтад худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын зар тавигдаж, шалгууралтыг зохион байгуулж нийлүүлэлтийн ажил хүлээгдэж байна.	70
5.4	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх.	ADB төсөл	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	89	209	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд байгууллагын даргын 2024.05.15-ны өдрийн Б/297 дугаартай тушаалаар нийт 19 аймгийн эрх зүйч мэргэжилтэй 115 сумын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх, 197 сумын улсын бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрхийг тус тус олгосноор нийт 312 улсын бүртгэгч суманд бүртгэл хөтлөх эрхтэй болсон. Тайлант хугацаанд суманд эд хөрөнгийн эрхийн улсын 26,057, хуулийн этгээдийн эрхийн улсын 7,938 (нэр баталгаажуулалт 3543, хуулийн этгээдийн бүртгэл 4395) бүртгэлийг тус тус хөтөлсөн байна.	100

5.5	Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийг шинэчлэх ажлыг эхлүүлэх	ADB төсөл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх хувь	0	60	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системийг шинэчлэх “Бодлогын даалгавар”-ыг боловсруулсан бөгөөд программ хангамжийн бодлогын даалгаврын дагуу нийт 12 ерөнхий, 33 дэд ажлыг хийж гүйцэтгэхээр боловсруулан төслийн нэгжид хүргүүлсэн.	30
			Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим систем /eRS/-ийг шинэчлэх хувь	0	60	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим системийг шинэчлэх “Бодлогын даалгавар”-ыг боловсруулан программ хангамжийн бодлогын даалгаврын дагуу 4 ерөнхий 12 дэд ажлыг хийж гүйцэтгэхээр боловсруулан төслийн нэгжид хүргүүлсэн.	
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
6.1.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын авлигын эрсдэлийг бууруулах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх. /2.6.2.3./	-	Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжүүлэн ажиллах	0	1	Монгол Улсын Засгийн газрын 49 дугаар “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” тогтоол, Монгол Улсын Их Хурлаас 2023.06.30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хөтөлбөрт тусгагдсан холбогдох арга хэмжээг Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ХЗДХСайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг ханган ажилласан.	100

6.2.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд нээлттэй болгох./4.3.1.2./	-	Бүртгэгдсэн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчдийн тооны өсөлтийн хувь	0	5	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу http://opendata.burtgel.gov.mn/ цахим хаягаар хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээллийг нээлттэй байршуулсан.	100
6.3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	11	16	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор 2024 онд 3 удаагийн видео, мэдээ 6 постер мэдээг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн салбарт байршуулсан.	100

			АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо	3	5	Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2024.04.02-ний өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 22 салбар эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, "Нэгдэе" аянд байгууллагын хэмжээнд нэгдэж 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, 9 дүүргийн үйлчилгээний нэгдсэн төв, цэгүүдээр сурталчилан, байгууллагын мэдээллийн цахим хуудаст байршуулсан.	
Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
7.1.	Байгууллагын 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	98	100	УБЕГ-ын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхыг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд тайлант хугацаанд 112 удаагийн сургалт зохион байгуулж 13,055 албан хаагч хамрагдсан байна. Үүнээс улсын бүртгэлийн байгууллагын 81 удаагийн дотоод сургалтаар 12,983 албан хаагч хамрагдсан бол Засгийн газрын болон бусад төрийн байгууллагын зохион байгуулсан 31 удаагийн сургалтад 72 албан хаагч тус тус хамрагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай.	100
7.2.	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх, холбогдох хуульд заасны дагуу	Төслөөр	Цахим сургалтын мэдээллийн баяжилтыг хийсэн хувь	80	100	Хүний нөөц, сургалтын нэгдсэн системийн Монгол бичгийн видео хичээл, цахим ном, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай видео хичээл, Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл дэд цэсийг нээж чиглэл, зөвлөмж, бүртгэл хөтлөх зааварчилгаа, видео заавар, сургалтын бичлэг, онлайн программд зураг хэрхэн оруулах тухай	100

	мэдээллийг цахим хуудаст байршуулах.					зааварчилгаа, бие даах хичээл болох ерөнхий мэдлэгийн хичээл, иргэний улсын бүртгэлийн хичээл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хичээл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хичээл, улсын бүртгэлийн нэгдсэн архивын хичээлийн 40 видео хичээлийн 30 хувийг шинэчлэн, нэмэлтээр Эрх зүйн хэлтсийн сар бүр гаргаж байгаа сэтгүүлийг байршуулсан бөгөөд нийт 2024 онд 254 албан хаагч үзэж судалсан байна.	
7.3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг хариуцлагын даатгалд даатгуулах	-	Даатгалд хамруулсан хувь	0	100	ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.01.24-ний өдрийн А/24 дугаар тушаалаар Хууль зүй дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2 дугаар хавсралтаар батлагдсан урсгал зардлаас санхүүжих төсөл арга хэмжээний 2.1.5-д тусгагдсан Улсын бүртгэлийн хариуцлагын даатгалын үйлчилгээ худалдан авах ажлын техникийн тодорхойлолт боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороонд газрын мэргэжилтэн ажиллаж 2024.04.09-ний өдөр үнэлгээний хороо хуралдаж гүйцэтгэгчийг шалгаруулсан ба 2024.04.29-ний өдөр гэрээ байгуулж 249 улсын бүртгэгчдийг хариуцлагын даатгалд бүрэн хамруулсан.	100
Дундаж үнэлгээ							92.55
Оноо							4.62

---oOo---